

APU COMPANY

Төгс. Төгөлдөр. Тунгалаг.

ЖИЛИЙН ТАЙЛАН

2020

1

Бидний тухай

- Эрхэм зорилго
- Үзэл баримтлал
- Үнэт зүйлс

4
5
5

2

Бизнесийн үйл ажиллагаа

- ТУЗ-ийн даргын захидал
- Гүйцэтгэх захирлын захидал
- 2020 оны үйл ажиллагааны хураангуй
- 2020 оны зах зээлийн нөхцөл байдал
- 2020 оны экспортын тойм
- 2020 оны санхүүгийн үйл ажиллагааны ерөнхий тойм
- Гүйцэтгэх удирдлагын баг
- АПУ Групп компанийн бүтэц
- Бидний хамт олон
- Байгууллагын хөгжил
- Эрсдэлийн удирдагаа

7
8
9
10
11
13
14
16
17
18
19

3

Компанийн засаглал

- Компанийн засаглалын бүтэц, үйл ажиллагаа
- Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн Удирдах Зөвлөл
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын статистик
- Хувьцааны мэдээлэл
- Ноогдол ашгийн мэдээлэл

22
22
23
24
26
27
28

4

Тогтвортой хөгжлийн тайлан

- Байгаль орчны бодлого
- Эрүүл мэнд ба Аюулгүй ажиллагаа
- Талуудын оролцоо, хамтын ажиллагаа
- ISO стандарт ба Чанарын удирдлагын тайлагнал

30
31
33
35

5

Санхүүгийн тайлагнал

- Дэлгэрэнгүй орлогын тайлан
- Санхүү байдлын тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Тайлагналын зарчим
- Тайлбар толь

38
39
40
41
42
44

Бидний тухай

- Эрхэм зорилго
- Үзэл баримтлал
- Үнэт зүйлс

ЭРХЭМ ЗОРИЛГО

АМЬДРАЛЫН БАЯР ХӨӨРТЭЙ МӨЧ БҮРИЙГ ХАМТДАА.



| ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ТӨГС. ТӨГӨЛДӨР. ТУНГАЛАГ.

[ТӨГС]

Бид бүхий л түвшинд чанарыг эрхэмлэж, хэрэглэгч, харилцагч, хамтрагчдынхаа эрхэм сонголт байна.

[ТӨГӨЛДӨР]

Бид баяр хөөртэй, дахин давтагдашгүй, нандин сайхан мөчүүдийг түгээнэ.

[ТУНГАЛАГ]

Бид хүн, нийгэм ба эх дэлхийд ээлтэй үйл ажиллагаа явуулж, байгальд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг алхам бүртээ багасгаж, гэрэлт ирээдүйг хамтдаа цогцлооно.

| ҮНЭТ ЗҮЙЛС

БУСДЫГ ДЭЭДЛЭН ЭРХЭМЛЭ

- Хүнсний болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд ханган ажилладаг.
- Бид байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа явуулж, эх дэлхийгээ хайрлан дээдэлдэг.
- Бид нийгэмдээ үйлчилж, нийгмийн хөгжил дэвшилд өөрийн үнэтэй хувь нэмрийг оруулдаг.
- Бид хууль дүрмээ чандлан сахиж, шударга ёсыг эрхэмлэн ажилладаг.

СУРАЛЦ. НЭЭ. ХӨГЖ.

- Бид мэдлэг, ур чадварыг эрхэмлэн дээдэлдэг. Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх нь ажилтан бүрийн эрхэм үүрэг.
- Хэрэглэгч, харилцагч, зах зээлийн талаарх мэдлэг, судалгаа, шинжилгээнд үндэслэн аливаа шийдвэрийг гаргадаг.
- Бид үргэлж шинийг судалж, эрэлхийлж, шинэ зах зээл, шинэ хил хязгаарыг нээхийг эрмэлздэг.

АМЖИЛТ ӨӨД ХАМТДАА

- Бид хамтын ажиллагаа, хамтын шийдвэр гаргалт, хүн бүрийн оролцоог бүрдүүлж, нээлттэй харилцааг эрхэмлэдэг.
- Харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан харьцааг бий болгон үр дүнтэй хамтран ажилладаг.
- “Би” бус “Бид” зарчмыг дээдэлдэг.
- Бид аливаад хамтдаа ялахын төлөө ажилладаг ба win-win зарчмыг дээдэлдэг.

ҮЛГЭРЛЭН МАНЛАЙЛ

- Бид хааш тэмүүлж, юунд зорьж буйгаа мэддэг.
- Бид салбар, зах зээл бүртээ манлайлахын төлөө ажилладаг.
- Аливаад эзний ёсоор хандаж, бусдыгаа уриалан дууддаг.
- Хүн бүр манлайлагч байхыг хүсдэг, бас чаддагт итгэдэг.
- Хүн бүр бусдыг үлгэрлэн манлайлж, нөлөөлж нийгмийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэдэг.

УЛАМЖЛАЛАА ХҮНДЭЛ, ШИНИЙГ БҮТЭЭ

- Бид үргэлж уламжлалаа дээдэлж, шинийг эрэлхийлж, шинэ шийдэл, шинэ бүтээгдэхүүн, шинэ үнэ цэнийг бүтээдэг.
- Ажилтан бүр нээлттэй санал санаачилга гаргаж, түүнийгээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн ажилладаг.
- Бид бусдаас түрүүлж, бусдаас түргэн хөдөлдөг.

2 Бизнесийн үйл ажиллагаа

- ТУЗ-ийн даргын захидал
- Гүйцэтгэх захирлын захидал
- 2020 оны үйл ажиллагааны хураангуй
- 2020 оны зах зээлийн нөхцөл байдал
- 2020 оны экспортын тойм
- 2020 оны санхүүгийн үйл ажиллагааны ерөнхий тойм
- Гүйцэтгэх удирдлагын баг
- АПУ Групп компанийн бүтэц
- Бидний хамт олон
- Байгууллагын хөгжил
- Эрсдэлийн удирдлага





Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын захидал

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ,
Өнгөрсөн 2020 он Дэлхий дахинд КОВИД-19 цар тахал нүүрлэж, бид бүхэнд ихээхэн сорилт, хүндрэл бэрхшээл тулгарсан жил байлаа. АПУ Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын хувьд би хамт олондоо энэ хүнд цаг үеийг хамтдаа даван туулахаар хичээн зүтгэж, сэтгэл зүрхээ зориулсанд нь гүнээ талархаж байна.

Зах зээлийн сорилтод дасан зохицох чадвар, хэрэглэгч, харилцагчдынхаа эрх ашгийг дээдэлдэг үзэл санаа бол АПУ Компанийн урт хугацааны хөгжил дэвшлийн үндэс билээ. 2020 оны их сорилтын жилд бид компанийнхаа эрхэм зорилго, үзэл баримтлал, үнэт зүйлсийг шинэчлэн тодорхойлж, ирээдүйд өндөр өгөөж өгөх зах зээлийн шинэ боломжуудыг эрэлхийлэн, бизнесийн цар хүрээгээ тэлэхийг зорьж ажиллалаа. Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрлэл, маркетингийн шинэлэг шийдэл, дэвшилтэт технологийг тасралтгүй хөгжүүлэн, бизнесийн үр өгөөж, өрсөлдөх чадвараа бэхжүүлэн сайжруулах ажлаа тууштай үргэлжлүүлэн хийсээр байна.

Үндэсний эдийн засаг, олон улсын худалдаа, санхүү удирдлагад олон сорилт тулгарсан амаргүй энэ цаг үед бид зах зээлийн орчин, хэрэглэгчийн чиг хандлагын өөрчлөлтөд тухай бүр зохицож, санхүүгийн хөрвөх чадвараа бэхжүүлэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулах зэргээр шуурхай арга хэмжээ авч ажиллалаа. Улс даяар хэрэгжүүлсэн удаа дараагийн хөл хорио, худалдаа үйлчилгээнд тавигдаж буй хязгаарлалууд борлуулалтад сөргөөр нөлөөлсөөр байгаа ч бидний цаашдын хөгжлийн суурь бат бөх хэвээр гэдэгт итгэлтэй байна.

АПУ Компани өөрийн онцлон анхаардаг дөрвөн чиглэл болох өндөр бүтээмжтэй хөгжил, бизнесийн үнэ цэнийн өсөлт, санаа зорилгоороо нэгдсэн хамт олон, компанид хүлээлгэх олон нийтийн итгэл үнэмшлийн хүрээнд өнгөрсөн жил ихээхэн ахиц дэвшил гаргасныг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн энэ цаг үеийг даван туулж буй олон мянган хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг харгалзан, бид АПУ ХК-ийн түүхэнд анх удаа жилд хоёр удаа ногдол ашиг хуваарилах шийдвэр

гаргасныг онцлон хэлэхэд таатай байна. 2020 оны нийлбэр дүнгээр нэгж хувьцаанд нийт 95 төгрөгийн ногдол ашиг хуваарилж буй нь түүхэн дээд амжилтаа дахин сайжруулсан үзүүлэлт билээ.

2020 оны 10 дугаар сард АПУ Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ")-д ХАЙНЕКЕН Азия Пасифик компанийн Ази, Номхон далайн бүс хариуцсан Хуулийн захирал, хатагтай Сэн И-Ин тус компанийг төлөөлөн ТУЗ-д ажиллаж байсан Ядамдоржийн Дамдинсүрэнг орлон сонгогдов. Я.Дамдинсүрэн нь 2017 онд Шунхлай Групп, Хайнекен компанийн хөрөнгө оруулалттай компаниудыг нэгтгэж, Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд тэмдэглэгдсэн томоохон үйл явдал болох компанийн нэгдлийн ажилд гар бие оролцон, АПУ ХК-ийн Стратеги эрхэлсэн захирал, улмаар ТУЗ-ийн гишүүнээр ажиллахдаа компанийн менежмент, ТУЗ-ийн үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсныг энэ ялдамд онцлон тэмдэглэж, ТУЗ-ийн даргын хувьд талархал илэрхийлж байна.

АПУ Компанийн хамт олон бид хэрэглэгчийн итгэлийг даасан бүтээгдэхүүн, зах зээлд эзлэх бат бөх байр суурь, тасралтгүй хөгжлийг эрхэмлэх байгууллагын соёлдоо түшиглэн, цар тахлын дараах амьдралын шинэ хэв маягт цаг алдалгүй шилжих зорилгыг 2021 ондоо дэвшүүлээд байгаа билээ. Цар тахлыг даван туулж, дэлхийн эдийн засгийн өсөлт, олон улсын аялал жуулчлал, худалдаа арилжаа сэргэх цаг ойрхон ирж буй гэсэн итгэл үнэмшлээр бид санхүүгийн сахилга бат, нарийн төлөвлөлттэйгөөр хөрөнгө оруулалтуудаа хийж, өндөр бүтээмжтэй, тогтвортой өсөлтийг ханган ажиллахыг зорьж байна. АПУ Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын багаас хувьцаа эзэмшигчид, харилцагч, хэрэглэгч, түнш хамтрагчдынхаа урт хугацааны эрх ашгийг цаг ямагт хүндлэн дээдэлж, нийгмийн хариуцлагаа өндөр түвшинд хэрэгжүүлэхээ илэрхийлж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн мэндчилье.

Пүрэвийн **БАТСАЙХАН**

Batsaikhan



Гүйцэтгэх захирлын захидал

Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажилладаг түнш байгууллагууд, хүндэт хэрэглэгч та бүхний амгаланг эрин мэндчилж байна.

Дэлхий даяар нүүрлээд буй Ковид-19 цар тахлын хүнд сорилтой тулгарсан 2020 оныг бид шуурхай хариу арга хэмжээ, төлөвлөлтийн уян хатан шилжилтэд тулгуурлан даван туулж үр дүнтэй ажиллалаа. Үүсээд буй шинэ нөхцөл байдалд дасан зохицож, ач холбогдлоор нь эрэмбэлэн чухалчилж төлөвлөхийг эрмэлзэн, олон зорилтоос илүү үр дүнд чиглэсэн дөрвөн томоохон зорилтуудаа төвлөрлөө.

Нэгдүгээрт. Бизнесийн өсөлт, өгөөж, өндөр гүйцэтгэлд хамгийн чухал хүчин зүйл бол хүн. Тиймээс хүн төвтэй менежментийн бодлого хэрэгжүүлж ажиллалаа. Бид АПУ компанийнхаа бизнесийн эрхэм зорилго, үнэт зүйлс, зарчмаа тодорхойлж ажил, амьдралдаа хэрэгжүүлэх чиг болгон тогтов. 2020 онд тэвчиж болох бүхий л зардлуудыг танан ажилласан боловч гагцхүү хүндээ зориулсан ажлуудад ихээхэн хүчин чармайлт гарган хөрөнгө зарцуулж ажиллалаа. Эрүүл мэндийн эрсдлийн даатгалд хамруулах, сэтгэл зүйн эрүүл мэнд, зайнаас ажиллах зохицуулалт, халдвар хамгааллын асуудалд онцгойлон анхаарах, цалин хөлс бууруулахгүй байх, нийгмийн асуудлыг шийдэх, хувь хүний хөгжлийг дэмжин эрчимжүүлэх гэх зэргээр энэ хүнд үед хүнээ дэмжиж болох бүхий л боломжуудыг хайн эрэлхийлж, шийдвэрлэж ажиллалаа.

Хоёрдугаарт. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хэмнэж болох зардлуудаа хэмнэх санаачилгуудыг дэмжин тухай бүрт арга хэмжээ авч ажиллахын зэрэгцээ ирээдүйгээ харсан дунд болон урт хугацааны өгөөж хүртэх төслүүдэд хөрөнгө оруулалт хийхэд анхаарав. 2020 онд бид бизнесийн тогтвортой байдлыг хангахын тулд олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Үүний нэг нь дэлхий даяар дижитал шилжилттэй зэрэгцэн алхаж буй энэ цаг үед санхүүгийн системийн шинэчлэлийн төсөл хэрэгжүүлсэн нь бүтээмжийн удирдлагад эергээр нөлөөлсөн процесс сайжруулалтын томоохон алхам боллоо.

Гуравдугаарт. Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөлөлд хамгийн их өртөж буй тусламж дэмжлэг шаардлагатай зорилот бүлгүүдэд бид анхаарал хандуулж нийгэмд чиглэсэн төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж ажиллав. “Хариуцлага нэмж, хамтдаа давь” малгай зорилгын дор цар тахлын нөлөөгөө өдрийн орлого нь тасалдсан айл өрхүүдийг дэмжих “Дэм дэмэндээ” төсөл, хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн бизнесийг дэмжих үйл ажиллагаа, халдварт цар тахалтай нүүр тулан тэмцэж байгаа ХӨСҮТ-ийн үйл ажиллагаа тэргүүтэй зорилтод бүлгүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явууллаа. Үүний зэрэгцээ бид тогтвортой хөгжлийн төлөөх хүчин чармайлтаа улам хурдасгаж, байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагааг эрхэмлэн усны хэрэглээг бууруулах тэр дундаа 7500 м.куб саарал усыг дахин ашиглаж, 5800 к.ватт цахилгаан ашиглалтыг хэмнэн, 2200 к.калори уур хэмнэхийн зэрэгцээ ашиглагдахгүй байсан зарим материалыг дахин ашиглахад анхаарч, эргэлтийн шил дахин ашиглах тал дээр онцгойлон хичээл зүтгэл гаргалаа. Үйлдвэрлэлийн хог хаягдлыг 30% бууруулан 17 сая ширхэг лонхыг дахин ашигласан ба уур амьсгалын өөрчлөлтөд сөргөөр нөлөөлж буй нүүрсхүчлийн хийг цуглуулан дахин ашиглаж дотоодын хэрэгцээг бүрэн хангахын зэрэгцээ гуравдагч талуудад борлуулсан байна.

Дөрөвдүгээрт. Үйлдвэрлэлийн шугамын оновчтойлыг амжилтай хэрэгжүүлснээр зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бүтээмжийг эрс нэмэгдүүлээ. Борлуулалт үйл ажиллагааны төлөвлөлтийн баг дотоод үйлчилгээний гэрээг шинэчлэн амжилтай мөрдүүлснээр борлуулалтын таамаглал, түүнд суурилсан материал, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн эргэц, бэлэн байдалд ихээхэн ахиц гарсны зэрэгцээ бүтээгдэхүүний тасалдал өмнөх оноос эрс буурсныг онцлох хэрэгтэй юм. Үйлдвэрлэл үйл ажиллагааны нэгжүүд маань зардлын удирдлагын төслийг санаачлан хэрэгжүүлж АПУ групп компанийн хэмжээнд манлайлан удирдаж 6.5 тэрбум гаруй төгрөгийн хэмнэлт бий болгож хувьсах зардал, тогтмол зардлаа тус тус бууруулан хамтын ажиллагааны үнэ цэн, соёлыг бий болгож 2021 оны зорилго, үйл ажиллагааны стратегийг бүхий л түвшинд хамтдаа хэлэлцэн тодорхойлж компанийнхаа хөгжлийн хурдасгуурт хувь нэмрээ оруулан амжилт бүтээлээр түүчээлэн ажиллалаа.

2021 он өмнөхөөс илүү хариуцлага шаардсан жил болох нь тодорхой. Гэхдээ аливаа сорилт нөгөө талдаа боломж дагуулдаг. Тиймээс ирээдүйн 5 жилд нийт борлуулалтын 20%-иас доошгүй хувийг экспортын орлогоор бүрдүүлэх том зорилгын суурийг тавих жил гэж итгэж байна.


Бусдыг эрхэмлэн дээдлэж, өдөр бүр суралцаж, өөрийгөө нээж, хөгжиж, бусадтайгаа хамтран ажиллаж ялангуяа бүх хүмүүс үлгэрлэн манлайлагч байж уламжлалаа хүндэтгэж, өдөр бүр шинийг санаачилж хариуцлага нэмж энэ цар тахлыг хамтдаа даван туульга гэж уриалж байна.

Цэвээнжавын ЭРДЭНЭБИЛЭГ


2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


↑4% Цэвэр борлуулалтын орлого /тэрбум төгрөг/




↑17% Цэвэр ашиг /тэрбум төгрөг/




~ Ажилчдын тоо



↓-12% Бүтээгдэхүүний нэр төрөл /SKU/



↑5% БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ /сая.литр/




ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ 5 ҮНДСЭН ЧИГЛЭЛ



SUSTAINABLE DEVELOPMENT GOALS

1,800,000 ГАРАА УГААЖ ЦЭВЭРЛЭХ УСЫГ ХЭМНЭВ.



Хан-Уул дүүргийн **4000** мод



300 мянган бут сөөг, **36** мянган м² талбайн зүлэг, ногоон байгууламжийн цистернуудийг саарал усаар цэнэглэв.



Үйлдвэрийн дотоод хэрэгцээнд саарал ус ашиглав.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ

- Ажилтнууддаа үнэн зөв мэдээллийг цаг тухайд нь хүргэж, сэтгэлзүйн асуудлыг анхаарч мэргэжлийн сэтгэл зүйчээр хангав.
- Коронавирусын халдварын эрсдэлээс сэргийлэх зорилгоор Үйлдвэрлэл, үйл ажиллагаа болон борлуулалтын хэсгийн ажилтнуудыг COVID-19 даатгалд хамруулсан.
- “Хариуцлага нэмж, Хамтдаа давъя” аяныг санаачлан зохион байгуулж цар тахлын голомтод бүх хүчээ дайчлан ажиллаж буй ОБЕГ, ХӨСҮТ, ДХИС-ийн нийт эмч, сувилагч, ажилтан албан хаагчид, сонсогч нарт дэмжлэг үзүүлж, нийгэм олон нийтэд халдвараас урьдчилан сэргийлж, хариуцлага нэмэхийг уриалсан компани ажил өрнүүлэв. Мөн АПУ компанийн нийт хамт олны зүгээс сайн дурын хандивын аян эхлүүлж Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн эмч сувилагч нарт мөнгөн тусламж үзүүлсэн.

2020 ОНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2020 онд Монгол улсын сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл



өмнөх онтой харьцуулахад
10%↑

Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл өсөлттэй байгаа нь цар тахлын үед хэрэглэгчид эрүүл мэнддээ чухал ач холбогдол өгч байгаатай холбоотой юм. Нийт зах зээлийн 60 гаруй хувийг сүүн бүтээгдэхүүн эзэлж байгаа бол үлдсэн 40 гаруй хувийг бусад сүүн бүтээгдэхүүнүүд эзэлж байгаа байна.

УС, УНДАА, ШҮҮСНИЙ ЗАХ ЗЭЭЛ

2020 онд Монгол улсын хийжүүлсэн ундааны зах зээл



өмнөх онтой харьцуулахад
2%↑

Савласан жимсний шүүсний зах зээл 12% өсөж 54 сая литр, савласан цэвэр усны зах зээл 6% буурч, 98 сая литр хүрсэн.



АРХИНЫ ЗАХ ЗЭЭЛ

2020 онд Монгол улсын архины зах зээл




өмнөх онтой харьцуулахад
13%↓

Зах зээлийн 1% орчим нь хямд үнэтэй архины сегмент, 67%-ийг дундаж үнэтэй архины сегмент, 32%-с дээш хувийг үнэтэй болон импортын архины сегментүүд тус тус бүрдүүлж байна. АПУ ХК нь 2020 оны байдлаар нийт 16 брэндийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлсэн.

ШАР АЙРГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2020 онд Монгол улсын шар айргийн зах зээл




өмнөх онтой харьцуулахад
5%↑

Нийт шар айргийн зах зээлд хэрэглэгчид үнэтэй болон хямд үнэтэй сегментийн брэндүүдийг сонгож хэрэглэх хандлага нэмэгдсэн. АПУ ХК нь 2020 онд нийт 9 брэнд бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлсэн байна.

ДАРСНЫ ЗАХ ЗЭЭЛ

2020 онд Монгол улсын дарсны зах зээл




өмнөх онтой харьцуулахад
6%↓

АПУ ХК нь дэлхийд алдартай Франц улсын "Maison Castel", "Albert Bichot", Испани улсын "Faustino", Чили улсын "Con-chayToro" болон Аргентин улсын "La Chamiza" брэндүүдийг дотоодын зах зээлд нийлүүлж байна.

ИМПОРТЫН ВИСКИ БОЛОН БУСАД ЗАХ ЗЭЭЛ

2020 онд Монгол улсын бор спиртэн бүтээгдэхүүний зах зээл



өмнөх онтой харьцуулахад
6%↓

Үүнээс виски 55%, Когняк/Брэнди 22%, Ликер 16%, Текилла 3%, Жин 2%, Рам 1% тус тус бүрдүүлж байна.

2020 ОНЫ ЭКСПОРТЫН ТОЙМ

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ОХУ-ын ихэнх мужид цар тахалтай холбоотойгоор 2020 оны 4-8 сарын хооронд согтууруулах ундааны борлуулалтад хэсэгчилсэн болон бүрэн хориг тавьсан. Хэдий тийм боловч 2019 онтой харьцуулахад архин бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний хувьд 45%-иар өссөн байна. Татспиртпром ХК нь 2020 оны 7-р сарын 1-ний өдрөөс Чингис хаан брэнд бүтээгдэхүүнийг ОХУ даяар борлуулж эхэлсэн билээ. Өнгөрсөн онд бид ОХУ-ын 57 хотын 326 худалдаа, үйчилгээний цэгүүдээр дамжуулан өөрийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэсэн байна. Мөн Эрхүү хотод АПУ ХК-ийн 100% хөрөнгө оруулалтай Гранд Ийст ХХК-ийг байгуулсан нь 2020 оны ололт амжилт билээ.

Экспортлож буй брэндүүд

Архи

1. Chinggis Khan
2. Soyombo
3. Evok
4. Chinggis GrandKhaan
5. Болор
6. Архи экспорт
7. Алтан түрүү

Шар айраг

1. Chinggis Khan
2. Алтан говь
3. Сэнгүр
4. Боргио

Хамгийн олон худалдаа, үйчилгээний цэгүүдээр борлуулалт хийсэн хотууд:

- | | | |
|-------------------|--------------------|---------------|
| 1. Эрхүү - 112 | 3. Казань - 28 | 5. Москва - 8 |
| 2. Улаан-Үдэ - 88 | 4. Красноярск - 27 | 6. Чита - 6 |

2020 ОНЫ ЭКСПОРТЫН ТОЙМ

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ 2020 онд Ковид-19 цар тахлын дэгдэлтийн улмаас удаа дараа хөл хорио тогтоож хил гааль, муж хоорондын тээвэр хөдөлгөөнд тодорхой хязгаарлалтууд тавьсан ба 2020 оны 5-р сараас эхлэн согтууруулах ундааны борлуулалт хэвийн байдалд хэсэгчлэн шилжсэн. 4-р сараас эхлэн ӨМӨЗО-ны 138 салбартай сүлжээ супермаркет дэлгүүрт нэвтэрснээр хэрэглэгчдийн гарт илүү ойртсон бөгөөд 2020 оны 6-р сарын 25-ны өдрөөс Шанхай хотын импортын шар айргийн сүлжээ ресторан болон супермаркет дэлгүүрүүдэд нэвтэрч борлуулалтаа нэмэгдүүлсэн билээ. Мөн БНХАУ-ын E-Commerce платформд шилжих ажлын хүрээнд 2020 оны 12-р сараас эхлэн Чингис хаан брэндийн архийг БНХАУ-ын томоохон онлайн худалдааны T-Малл платформд байршуулсан. Улмаар Сэнгүр брэндийн шар айргийг байршуулах ажил эрчимтэй үргэлжилж байна. 2020 онд БНХАУ дахь борлуулалт биет хэмжээгээр өмнөх оны мөн үеэс 7%-иар өсөөд байна.

Экспортлож буй брэндүүд

Архи

1. Chinggis Khan
2. Soyombo
3. Chinggis GrandKhaan
4. Болор

Шар айраг

1. Сэнгүр
2. Сэрүүн

2020 ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТОЙМ

		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан		Өсөлт %
		2020	2019	
БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ	мян.литр	139,650	132,641	5.3%
ОРЛОГО ҮР ДҮН				
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	492,337	472,634	4.2%
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	115,840	99,395	16.5%
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	88,743	76,113	16.6%
БАЛАНС				
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	204,585	192,641	6.2%
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	351,078	352,867	-0.5%
Нийт хөрөнгө	сая.төг	555,663	545,507	1.9%
Нийт өр төлбөр	сая.төг	94,048	64,225	46.4%
Нийт эздийн өмч	сая.төг	461,616	481,283	-4.1%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	555,663	545,507	1.9%
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	144,433	88,636	63.0%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(36,114)	(21,280)	69.7%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(94,925)	(78,363)	21.1%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	14,024	(11,089)	-226.5%
Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	50,035	61,124	-18.1%
Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	64,059	50,035	28.0%
ТАТВАР ТӨЛӨЛТ				
Онцгой албан татвар	сая.төг	166,882	175,390	-4.9%
Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого	сая.төг	48,065	62,170	-22.7%
Бусад	сая.төг	49,967	66,335	-24.7%
Нийт татвар төлөлт	сая.төг	264,914	303,895	-12.8%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	36,642	22,227	64.9%

ГҮЙЦЭТГЭХ
УДИРДЛАГЫН БАГ



ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ
Гүйцэтгэх захирал



ХОУ ТЭЙК ПЭН
*Үйлдвэрлэл, үйл ажиллагаа
эрхэлсэн захирал*



ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ
Санхүү эрхэлсэн захирал



ГАЛСУМЪЯАГИЙН БАЯРМАГНАЙ
*Борлуулалт, Байгууллагын
Харилцаа эрхэлсэн захирал*



АРИУНАА ДАНДАРОВА
Маркетинг эрхэлсэн захирал



ЦООДОЛЫН ЭРДЭНЭЖАРГАЛ
Гадаад худалдаа эрхэлсэн захирал

ГҮЙЦЭТГЭХ
УДИРДЛАГЫН БАГ



ШИПИЛОВЫН ДӨЛГӨӨН
*Хүний нөөц, Захиргаа
эрхэлсэн захирал*



САНЖИЙН ГАНЗОРИГ
*АПУ Дэйри ХХК-ийн
Гүйцэтгэх захирал*



БАТХҮРЭЛИЙН ЧИНТОГТОХ
*Спирт Бал Бурам ХХК-ийн
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал*




БАТСАЙХАНЫ ГАНТИГ
*Байгууллагын Стратеги
эрхэлсэн захирал*



ШАСНААБАДРААГИЙН БАТЖАРГАЛ
*Байгууллагын Харилцаа
эрхэлсэн захирал*

АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ



БҮТЦЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

АПУ ХК-ийн 100%-ийн эзэмшлийн охин компани Гранд Ист ХХК-ийг үүсгэн байгуулж, 2020 оны 10 сарын 09-ний өдөр ОХУ-ын хуулийн этгээдээр бүртгүүлсэн.


БИДНИЙ ХАМТ ОЛОН



 **2016**
Нийт ажилтан

1290 Үйлдвэрийн ажилтан




1240 
Нийт эрэгтэй ажилтан



 **776**
Нийт эмэгтэй ажилтан


307 Захиргааны ажилтан



350 Борлуулалт, түгээлтийн ажилтан



7.8  
Ажилчдын дундаж ажилласан жил

36.4 
Ажилтнуудын дундаж нас

БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ

 АПУ ГРУПП КОМПАНИ НЬ АЖИЛТНУУДЫН УР ЧАДВАРЫН ХӨГЖИЛД НИЙТ

351 УДААГИЙН

13496 

СУРГАЛТУУД ЗОХИОН БАЙГУУЛЖ ДАВХАРДСАН ТООГООР

6481  АЖИЛТАН

ХАМРАГДАН

₮879 САЯЫН

ХӨРӨНГӨ

ОРУУЛАЛТ ХИЙЖЭЭ

МЕНТОРШИП ХӨТӨЛБӨР



FAST TRACK ХӨТӨЛБӨР

Шинэ төгсөгчдөд зориулсан



ИНЖЕНЕРҮҮДЭД ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨР



АПУ АКАДЕМИ

Сургалтууд



2020 онд байгууллагын хөгжлийн хүрээнд дараах хөтөлбөр, сургалт хөгжлийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүллээ.

САНААЧИЛГЫН АЯН

Сургалтууд



FLMDP ХӨТӨЛБӨР

Дунд шатны менежерүүдийг хөгжүүлэх



АНГЛИ ХЭЛНИЙ ЯРИАНЫ КЛУБ

Гадаад багштай



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Дэлхий дахинаа хүн амын эрүүл мэнд болон нийгэм, эдийн засаг, санхүүгийн тогтолцоо, бизнесийн орчин гээд бүхий л чиглэлд асар хүчтэй, гэнэтийн цохилт үзүүлж буй өнөө үеийн хүн төрөлхтний өмнө тулгарсан хүндхэн сорилтын нэг бол яахын аргагүй Ковид-19 цар тахал юм.

Монгол улсын хувьд урт хугацааны хөл хорио тогтоосны улмаас бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаа доголдох, тасалдах хүндрэлүүд учирч байна.


Манай компани ч мөн адил уг асуудалтай нүүр тулсан хэдий ч эрсдэлийг урьдчилан таамаглаж, үр дагаврыг бууруулах нэгдсэн аргачлалын дагуу боломжит хэмжээнд зардлаа танах, гол чиглэл рүү төвлөрөх, хуримтлал үүсгэх замаар богино хугацаанд, хурдтай шийдвэрүүдийг гарган ажиллаж байна. Ингэснээрээ бид цомхтгол хийхээс ангид байж цалингийн тасалдал үүсгэхгүй байх тал дээр анхааран, шаардлагатай ажилтнуудаа Ковид-19 даатгалд хамруулж, хэрэглэгчээ чанартай бүтээгдэхүүнээр тасралтгүй ханган ажиллаж чадсан билээ. Цаашид бид цар тахлын дараа үе буюу Ковид-19 цар тахалтай зэрэгцэн, үүссэн нөхцөл байдалд дасан зохицож, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллах шаардлага үүсч байна.

2020 онд АПУ групп компанийн хэмжээнд эрсдэлийн нэгдсэн бүртгэл үүсгэн, эрсдэлийн нарийвчилсан анализ үнэлгээ хийх, бууруулах

төлөвлөгөөг боловсруулан, мөшгөлт хийх, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “ARM” буюу эрсдэлийн удирдлагыг автоматжуулах төслийг санаачлан амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь цар тахлын үед зайнаас ажиллах нөхцөлд нэн тохиромжтой, үйл ажиллагааг хурдатгасан ажил байлаа. Үүний үр дүнд эрсдэлийн

удирдлагын процесст удирдлагуудын оролцоо нэмэгдэж, ашиглахад хялбар, хэрэглэгчийн смарт цонхтой, эрсдэлээс урьдчилан сэргийлэх гурван шатны алерттэй, нэгдсэн дашбоардтай болсноор эрсдэлийн удирдлагын чиглэлд шуурхай шийдвэр гарган, бүтээмжийг үлэмж дээшлүүлэн ажиллах болсон.

ЭРСДЭЛИЙН ЗУРАГЛАЛ



2021 ОНД УЧИРЧ БОЛОХ ТОП ЭРСДЭЛҮҮД

● ТОП ЭРСДЭЛҮҮД	ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ?	ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ?
<p>● КОВИД-19 ЦАР ТАХАЛ</p>	<p>Цар тахлын үеийн урт хугацааны, үргэлжилсэн хөл хорионы улмаас жижиг дунд бизнес төдийгүй томоохон татвар төлөгч компаниудын үйл ажиллагаа доголдох, орлого буурах нөхцөл бүрдсэн.</p> <p>Манай компанийн хувьд хөл хорионы үед сүү, сүүн бүтээгдэхүүн болон ариутгалд шаардлагатай спиртийн үйлдвэрлэлийг тасралтгүй ажиллуулж хэрэглэгчдээ чанартай бүтээгдэхүүнээр хангаж байсан ч согтууруулах ундааны борлуулалт хязгаарлагдсаны улмаас энэ чиглэлийн бүтээгдэхүүний борлуулалт тасалдах, улмаар орлого буурах сөрөг үр дагавар учирсан.</p> <p>Мөн цар тахлын улмаас алсын зайнаас ажиллах шаардлага үүсч энэ нь бодит үнэлэмжгүйгээр урт хугацаанд илүү цагаар ажиллах, эрч хүчтэй хүсэл эрмэлзэл дүүрэн ажиллах байдал сулрах, багаар ажиллахад хүндрэл учрах, ойлголцлын зөрүү үүсэх зэрэг асуудлуудыг дагуулж байгаа ч нөгөө талаараа асар хурдтай дижитал өөрчлөлтөд шилжих боломж олгож байна.</p> <p>Цаашид дотооддоо бүртгэгдсэн өвчлөлийн тархалт нэмэгдэх, хяналтаас давах, үргэлжилсэн хөл хорио, хязгаарлалт тогтоох зэрэг нь бизнесийн үйл ажиллагаа болон ард иргэдийн амьдралд улам дарамт учруулах эрсдэлтэй байна.</p>	<p>ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ?</p> <ul style="list-style-type: none"> • Шаардлагатай бүхий л зардлыг тэвчих, нэн чухал чиглэлд санхүүжилт хийх, зээлийн болон авлагын бодлогод анхаарах • Боломжит ажилтнуудыг зайнаас ажиллуулах, ажлын байран дээр аюулгүй ажиллах бүхий л боломж нөхцөлийг хангах буюу зай барих, маск зүүх, гарын ариун цэвэр сахих, тусгаарлах өрөө гаргах, тогтмол ариутгал хийлгэх, шаардлагатай ажилтнуудыг Ковид-19 даатгалд хамруулах, шаардлагатай мэдээ, мэдээллийг тогтмол, шуурхай өгч, ажилтнуудыг сэтгэл санаагаар дэмжин ажиллах зэргээр нэгдсэн дэг журмын дагуу ажиллуулах • Үүссэн хүндрэлийг хамтдаа даван туулах чиглэлд “Хариуцлага нэмж, хамтдаа давьа” уриан дор нийгэмд чиглэсэн олон ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.
<p>● НИЙГМИЙН СӨРӨГ ХАНДЛАГА НЭМЭГДЭХ</p>	<p>Нийгмийн сүлжээнд компанийн имидж болон брэндтэй холбоотой сөрөг мэдээллүүд өргөн цар хүрээг хамарч цензургүй, хяналтгүй тархсанаар брэндүүд болон компанийн нэр хүндэд сөрөг нөлөө ихээр үзүүлж байдаг. Ялангуяа согтууруулах ундааны борлуулалт хязгаарлалттай энэ үед хүмүүс хувь хүний гар дээрээс хадгалалтын горим алдагдсан, чанар муутай, стандартын шаардлага хангахгүй бүтээгдэхүүн худалдан авч зрүүл мэндээрээ хохирох явдал гарах нь салбарын хувьд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж, анхаарал хандуулах шаардлагатай хэсэг болдог.</p>	<p>Бизнесийн тогтвортой ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, цаг тухай бүрд нь зохих арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн бүтээгдэхүүнийг зохион бүтээхээс эхлэн эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн түгээлтэд гаргах хүртэлх процесст чанар стандартыг өндөр түвшинд ханган хэрэглэгчдийнхээ хүсэл сонирхолд нийцсэн, дээд зэргийн чанартай, бүтээгдэхүүн хүргэх, түүгээрээ дамжуулан зохистой хэрэглээг нийгэмд таниулах замаар уг эрсдэлийг удирдан ажиллахыг эрмэлздэг.</p>
<p>● ҮР ТАРИАЛ/ УЛААН БУУДАЙН ХОМСДОЛ</p>	<p>Дэлхийд улаан буудай үр тарианы үйлдвэрлэл, нийлүүлэлт сайн байгаа бөгөөд Австрали, ОХУ зэрэг улс орнуудын ургац хураалт, гарц уг статистикт онцлох эерэг нөлөө үзүүлж байгаа. Харин дотоодын улаан буйдайн нөөц харьцангуй сайн байгаа ч ургац хураалтын үед цаг агаарын гамшигт үзэгдэл болсон.</p>	<p>Гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэлтэй эрсдэлийг удирдахад хүндрэлтэй ч нийлүүлэгч байгууллагуудтай нягт хамтран ажиллах, эрэлтийн оновчтой төлөвлөгөөнд тулгуурлан улаан буудайн нөөцийг оновчтой төвлөрүүлэхээр зорьж ажиллаж байна.</p>
<p>● ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛ</p>	<p>Дэлхийн Банкны таамагласнаар Монголын эдийн засаг ирэх 2020 болон 2021 онд харгалзан 4 болон 14%-р буурах төлөвтэй байна. Зөвхөн Монгол төдийгүй дэлхий дахинаа цар тахлаас шалтгаалан нийгмийн эрүүл мэнд, эдийн засгийн хямрал дэлхийн 2-р дайнаас хойш үзэгдэж байгаагүй хэмжээнд хүрсэн. Гэхдээ чинээлэг орнууд үүнийг хүндрэл багатай даван туулж чадаж байгаа ч хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийн хямралд их өртөж байна. Цаашид эдийн засгийн нөхцөл байдал энэ хэвээр үргэлжилбэл бизнесийн орчин ихээр хумигдах бөгөөд үүний тулд маш их хүчин чармайлт, урт хугацааны хэмнэлтийн горимыг улс даяар авч хэрэгжүүлэх шаардлага үүсэхээр байна.</p>	<ul style="list-style-type: none"> • Компанийн хувьд ямар ч тохиолдолд хэмнэлтийн горимыг чангаруулах, шаардлагагүй зардлуудыг тэвчих • Урт хугацааны мөнгөн хөрөнгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх зэргээр ажиллаж байна.

*Дээрх статистик мэдээллийг Монгол банк, УСТХ, ХХААХҮЯ болон Дэлхийн банк(WB), Олон улсын валютын сан(IMF), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO) зэрэг Монголын болон олон улсын байгууллагуудын тайлан мэдээ дээр тулгуурлан 2020.12 сарын байдлаар бэлтгэсэн болно.



3 Компанийн засаглал

- Компанийн засаглалын бүтэц, үйл ажиллагаа
- Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн Удирдах Зөвлөл
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын статистик
- Хувьцааны мэдээлэл
- Ногдол ашгийн мэдээлэл



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА


Оноосон нэр: **АПУ**
Хэлбэр: **Хувьцаат компани**
МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал: **I**
Хувьцаа эзэмшигчдийн тоо: **6998¹**
Компанийн эрх барих дээд удирдлага: **Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)**
ХЭХ-ын чөлөөт цагт компанийг удирдах этгээд: **Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)**
Гүйцэтгэх удирдлага: **Гүйцэтгэх захирал (Хувь хүн)**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ²

Steppe Beverage KFT
13.44%

БУСАД
5.53%

HEINEKEN
25%




SHUNKHLAI GROUP
56.03%

2020 онд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтэц болон эзэмшлийн хувь хэмжээнд өөрчлөлт ороогүй.

¹ ҮЦТХТ ХХК-аас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гаргасан хувьцааны төвлөрлийн судалгааны мэдээлэл
² Дээрхийн адил

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ИРЦ 2016-2020



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 20-ны өдөр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 хороо, Махатма Гандийн гудамж 39, Корпорейт Хотел энд Конвеншн Цэнтрийн 4 давхарт байрлах Концертын танхимаас компанийн цахим хуудсаар шууд дамжуулан, анх удаа цахим хэлбэрээр зохион байгуулав. Хурал 95.42%-ийн ирцтэй явагдаж, дараах шийдвэрийг гаргав. Үүнд:

1. АПУ ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 08 сарын 21-ний өдрөөс 10 сарын 02-ны өдрийн хооронд эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулав. Хурал 95.2%-ийн ирцтэй явагдаж, доорх шийдвэрүүдийг гаргав. Үүнд:

1. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаагаар сонгов.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит бус эчнээ санал хураалтаар ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож, тус эчнээ санал хураалтын дүнг баталгаажуулах тухай 2020 оны 10 сарын 14-ний өдрийн тогтоолоор шинэ бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаатай сонгосон.



ПҮРЭВИЙН БАТСАЙХАН
ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга

Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч
Скайтел ХХК-ийн ТУЗ-ийн дарга, гишүүн
2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга



БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР
ТУЗ-ийн ердийн гишүүн

Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



СЕРГЕЙ ГРОМОВ
ТУЗ-ийн ердийн гишүүн

Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



КЕННЕТ ЧУ
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон
далайн бүсг хариуцсан Гүйцэтгэх захирал
2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



ЯДАМДОРЖИЙН ДАМДИНСҮРЭН
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен Азия Пасифик компанийн Төслийн
удирдагч
2019-2020 онд АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



ТОМАС ХОЛЛАНД
ТУЗ-ийн ердийн гишүүн

Девелопмент Финанс Азия компанийн Хөрөнгө
оруулалт хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал
2019 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ӨЛЗИЙДЭЛГЭРИЙН БАТБАЯР

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Баттур Трейвэл ХХК, Улаанбуудайн эх газар
ХХК-ийн Ерөнхий захирал
Бату Дижитал ХХК-ийн ТУЗ-ийн дарга
2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч
2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



ЧАДРААБАЛЫН АРИУНСАН

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн

01. АУДИТЫН ХОРОО:

- Ж.Үнэнбат (Хорооны дарга)
- Я.Дамдинсүрэн (2020.10.14-нөөс өмнө)
- Сэн И-Ин (2020.10.14-нөөс хойш)
- Ө.Батбаяр

02. НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО:

- П. Батсайхан (Хорооны дарга)
- Ө. Батбаяр
- Ё. Гэрэлчулуун

03. ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО:

- Ё. Гэрэлчулуун (Хорооны дарга)
- Ж. Үнэнбат
- Кеннет Чу

ТУЗ-ИЙН ХУРЛЫН СТАТИСТИК

АПУ ХК-ийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 01 сарын 25-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийн дагуу АПУ ХК-ийн охин болон хараат компани, тэдгээрийн охин болон хараат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг давхар хэрэгжүүлдэг. Иймд, ТУЗ-ийн хурлаар АПУ ХК-ийн ТУЗ-ийн хурлын болон охин компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрүүдийг гаргадаг.

ОГНОО	ИРЦ	БАТАЛСАН ТОГТООЛЫН ТОО
2020.01.21	100%	3
2020.02.14	100%	17
2020.03.02	100%	1
2020.05.20	100%	1
2020.06.09	100%	6
2020.08.13	100%	5
2020.10.14	100%	2
2020.10.23	100%	1
2020.12.08	100%	6
Нийт	100%	42

Тус онд зохион байгуулсан ТУЗ-ийн хурал, эчнээ санал хураалтад ТУЗ-ийн бүх гишүүн 100% оролцсон байна.

2020 онд Аудитын хороо 2 удаа, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо тус бүр 1 удаа хуралдаж, хариуцсан чиг үүргийн хүрээнд санал зөвлөмж, шийдвэр гаргаж ажиллалаа.

ТУЗ-ийн цалин урамшуулал:

ТУЗ-ийн дарга болон гишүүдэд сар бүр тогтмол цалин олгодог бөгөөд үйл ажиллагааны гүйцэтгэлтэй уялдсан урамшууллын тогтолцоо байхгүй.

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК-ийн нийт хувьцаа
1,064,181,553

Халаасны хувьцаа
1,206,810

Эргэлтэд буй хувьцаа
1,062,974,743

2020 оны байдлаар хувьцааны арилжааны үнийн дүнгийн эрэмбээр 8-д, тоо хэмжээний эрэмбээр 13-т жагссан байна. Хөрөнгийн бирж дээрх зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани нийт зах зээлийн үнэлгээний 91 хувийг эзэлж байгаа бөгөөд үүнээс АПУ ХК хамгийн өндөр үнэлгээтэй буюу 644 тэрбум төгрөг, нийт үнэлгээний 21.3 хувийг эзэлж байна.

- Хаалтын дундаж ханш 573.3 төгрөг
- Хамгийн өндөр хаалтын ханш 657.4 төгрөг
- Хамгийн бага хаалтын ханш 512.4 төгрөг байсан.



Жилийн арилжааны мэдээллийн график

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

2020 оны I хагас жил
37.5

2020 оны II хагас жил
57.5

АПУ ХК-ийн ТУЗ-ийн хурлын 2020 оны 02 сарын 14-ний өдрийн 20/07 тоот тогтоолоор Компанийн ногдол ашгийн журамд нэмэлт өөрчлөлт оруулж, хагас жилээр ногдол ашиг хуваарилж болох ба энэ шийдвэрийг хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор гаргах зохицуулалтыг тусгасан.


Ийнхүү 2020 онд хоёр удаа буюу нэгдүгээр хагас жилд нэгж хувьцаанд 37.5 төгрөг, хоёрдугаар хагас жилд 57.5 төгрөг, нийт 95 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Энэ нь тухайн жилийн нэгж хувьцаанд ногдох цэвэр ашгийн 120 орчим хувьтай тэнцэх тул тодорхой хувийг өмнөх жилүүдийн хуримтлагдсан ашгаас тооцож санхүүжүүлэхээр болов. Хоёрдугаар хагас жилд зарласан ногдол ашгийг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр 2021 оны 03 сарын 31-ний өдөр болно.

АПУ компани 2010-2018 онуудад үйл ажиллагаагаа шинэчлэн өргөжүүлэх зорилгоор нийт 150 сая гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийж, гадаадын урт хугацааны зээлийн санхүүжилт татсан учраас тухайн хугацааны ногдол ашиг хуваарилах бодлогод тодорхой хэмжээний хязгаарлалт тавиад байсан билээ. Тэдгээр хөрөнгө оруулалтын төслүүдийг амжилттай

хэрэгжүүлж, зээлээ бүрэн эргэн төлж дуусгасан тул хувьцаа эзэмшигчдэдээ ийнхүү хуримтлагдсан ашгаас ногдол ашиг тооцож олгож байгаа нь цар тахлын хүнд үед хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалсан шийдвэр боллоо.

Ногдол ашгийн төлбөрийг компанийн нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан, таваас дээш хувийг эзэмшигчдэд албан хүсэлтийн дагуу компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.

НОГДОЛ АШГИЙН ХУВААРИЛАЛТ (2016-2020) ТӨГ



Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)



4 Тогтвортой хөгжлийн тайлан

- Байгаль орчны бодлого
- Эрүүл мэнд ба Аюулгүй ажиллагаа
- Талуудын оролцоо, хамтын ажиллагаа
- ISO стандарт ба Чанарын удирдлагын тайлагнал



БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

АПУ хувьцаат компанийн бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь нийгэм, эдийн засаг, хүн баялагт үнэ цэн бүтээхэд чиглэж байна. “Тогтвортой Хөгжил” – ийн үндсэн суурь зарчим болох ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧНЫ тэнцвэртэй хөгжлийг хангахаас гадна Хүний хөгжлийн тогтвортой бодлогод онцгойлон анхаарч, урт хугацаанд үр ашигтай ажиллахыг эрхэмлэж байна. Бид 2020 онд өөрийн үйлдвэрлэл болон бүхий л үйл ажиллагаандаа Монгол Улсын байгаль орчны холбогдох хууль, тогтоомж, олон улсын стандарт, шаардлагуудыг мөрдөн ажиллахын зэрэгцээ байгаль орчинд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүд эрчимтэй хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд усны ундаргаа хайрлан хамгаалах, нүүрсхүчлийн хийн ялгарлыг багасгах, эрчим хүч хэмнэх, хог хаягдал, орчны бохирдлыг багасгах чиглэлд олон үр өгөөжтэй ажлууд хэрэгжүүлээ.



УС

АПУ компани нь цэвэр усны эх үүсвэрийг хайрлан хамгаалах, нөөцийг зүй зохистой ашиглах, хэмнэх, усыг дахин ашиглах үүднээс нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны хэрэглээг бууруулахад гол анхаарлаа хандуулан ажилладаг. Энэ хүрээнд бид 1 хектолитр шар айраг үйлдвэрлэхэд шаардагддаг усны хэрэглээг өмнөх оноос 12 хувиар, 1 хектолитр архи үйлдвэрлэхэд шаардах усны хэрэглээг 2 хувиар тус тус бууруулж, 2020 онд 11 сая литр ус дахин ашиглаж, дараах нэгж хэсгүүдэд ашиглаж байна.

ЭРГЭЛТИЙН ШИЛ ТАТАН АВАЛТ

АПУ компанийн хувьд эргэлтийн шилний татан авалтаар жилд дунджаар 23 нэр төрлийн 25 сая шил эргүүлэн татаж, үйлдвэрийн эргэлтэд дахин ашиглаж байна. Бид орон даяар 3000 гаруй салбараар дамжуулан шилээ татан авдаг.



НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙ

Байгаль орчиндоо ээлтэй шийдэл боловсруулж жилд 1.600.000 кг нүүрсхүчлийн хийг агаарт хаягдахаас сэргийлэн 99,9 хувь хүртэл цэвэршүүлж, ус, ундаа үйлдвэрлэлдээ ашиглахаас гадна зэрэг томоохон компаниудад нийлүүлдэг.



ЭРЧИМ ХҮЧ

АПУ ХК нь эрчим хүчний хэрэглээг бууруулах, алдагдлыг багасгах зорилтын хүрээнд өнгөрсөн хугацаанд цахилгаан хуваарилах түгээх байгууламжийн шинэчлэл, эрчим хүчний хэмнэлтэй системийн суурилуулалт, дулааны алдагдлыг бууруулах хөтөлбөр, уурын конденсацыг халаалтад дахин ашиглах шийдэл боловсруулан, үйлдвэрийн хаягдал уураар 1200м2 талбайг халааж, жилд 2000 метр.куб халуун ус хэмнэж байна. Мөн LED гэрэлтүүлгийн шинэчлэлийг 90 хувьтай хийж, дэд станцаа шинэчилснээр жилд 34632 кВт цахилгаан хэмнэж ажиллалаа.



ХОГ ХАЯГДАЛ

АПУ ХК нь үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлыг зохистой хэмжээнд хүртэл бууруулах, дахивар хог хаягдлаа эргүүлэн ашиглах хүрээнд хэд хэдэн чиглэлээр ажилласан. Тухайлбал ажилтнуудынхаа дунд хогоо ангилан хаях дадал хэвшил бий болгох үүднээс хог хаягдал гарах эх үүсвэр, цэг бүрт тохирох төрлийн хогийн савнуудыг байрлуулсан. Бид хог хаягдлаа дахивар болон идэвхгүй хаягдал зэргээр дөрвөн төрөлд ангилж, улмаар цааш нь зохих байдлаар хянан удирддаг. Үйлдвэрлэлээс гарч буй органик түүхий эд болох улаан буудай, арвайн соёолжийн үлдэгдлийг мал, амьтны тэжээлийн зориулалтаар малчид, фермерүүдэд тогтмол нийлүүлж байна.



1,800,000

СУРАГЧИЙН НЭГ ЖИЛИЙН

ГАРАА УГААЖ ЦЭВЭРЛЭХ УСЫГ ХЭМНЭЛЭЭ.

11 сая литр усыг дараах цэгүүдэд эргүүлэн ашиглалаа.

- Хан-Уул дүүргийн **4000** мод, **300** мянган бус сөөг, **36** мянган м2 талбайн зүлэг, ногоон байгууламжийг услах цистернүүдийг цэнэглэх.
- АПУ компанийн ажилчдын **3000** гаруй хос ажлын хувцас хэрэгслийг угаах.

- **15** мянган м2 талбайн үйлдвэрийн анхан шатны цэвэрлэгээ (шал угаах).
- **108** түгээлтийн автомашинуудыг угаалга цэвэрлэгээ.
- Ариун цэврийн өрөө (почкинд ашиглах) зэрэг нийт **67** цэгт ашиглалаа.

ЭРҮҮЛ МЭНД БА АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА



Зорилго: **АЖИЛТАН БҮР АЮУЛГҮЙ АЖИЛЛАЖ, ГЭР БҮЛДЭЭ АЗ ЖАРГАЛТАЙ ОЧИХ**



ОСОЛ, БЭРТЛИЙН ДАВТАМЖ

200,000

хүн цаг тутамд ногдох үзүүлэлт

0.19

2019 онтой харьцуулахад **58% ↓**

2018 онтой харьцуулахад **87% ↓**



ОСОЛД ДӨХСӨН ТОХИОЛДОЛ МЭДЭЭЛЭЛ

3400

аюул, болон осолд дөхсөн тохиолдол мэдээлэгдсэнээс жилийн эцэст

85% -ийг

залруулан хаах арга хэмжээ авсан байна.

Групп компанийн ажилтнууд 2020 онд нийт 3400 гаруй тооны осолд дөхсөн тохиолдлуудыг мэдээлсэн нь дунджаар нэг ажилтан 2.5 болзошгүй аюулыг мэдээллэж эрсдлээс хамгаалсан байна. Ажлын байрны аюул эрсдэл буюу осолд дөхсөн тохиолдлыг олон тоогоор бүртгэж мэдээлсэнээр хэн нэгэн ажилтныг болзошгүй аюул осолд өртөхөөс урьдчилан сэргийлдэг чухал ач холбогдолтой. Энэ нь Германы Хенрих Берд нарын эрдэмтдийн гаргасан онолоор 600 тохиолдол тутамд нэг хүртэлх тооны нас баралт бүртгэгддэг тул 3400 осолд дөхсөн тохиолдол бүртгэгдсэн байгаа нь 5 хүртэлх амь нас эрсдэх магадлалтай болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж чадсан өндөр үзүүлэлт юм.



“АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ МАНЛАЙЛАГЧ АЯН”

Агуулах, тээвэр, түгээлт, борлуулалтын хэсгүүдийг хамруулан зохион байгуулсан.



ДААТГАЛ

Коронавирусын халдварын эрсдэлээс сэргийлэх зорилгоор

Үйлдвэрлэл, үйл ажиллагаа болон борлуулалтын хэсгийн



1360 орчим ажилтнуудыг

COVID-19 даатгалд хамруулсан.

ЭРҮҮЛ МЭНД БА АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА



АМЬ НАСАА ХАМГААЛАХ 12 ДҮРЭМ



СОГТУУРАХ, МАНСУУРАХААС
ЗАЙЛСХИЙ



ЗӨВШӨӨРӨГДСӨН
ХУРДААР ЯВ



НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙТЭЙ
ОРЧИНД ШААРДЛАГАТАЙ АРГА
ХЭМЖЭЭГ ХАНГАЖ АЖИЛЛА



ӨНДӨРТ АЖИЛЛАХДАА
УНАХААС СЭРГИЙЛ



ЖОЛООНЫ АРД УТСААР
ЯРИХДАА ЧИХЭВЧ АШИГЛА



ЭРХТЭЙ, ЗӨВШӨӨРӨГДСӨН
БОЛ ЖОЛООД



ХИМИЙН БОДИСТОЙ АЖИЛЛАХ
ҮЕДЭЭ ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛ



ХАЛУУН АЖЛЫГ
ЗӨВШӨӨРӨЛ АВЧ ХИЙ



СУУДЛЫН БҮСЭЭ ЗҮҮ,
ХАМГААЛАЛТЫН МАЛГАЙ ӨМС



МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ЗАСВАР
ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХДЭЭ ЦООЖ, ПАЙЗ ӨЛГӨ.



ХЯЗГААРЛАГДМАЛ ОРЧИНД
ОРОХДОО ЗӨВШӨӨРӨЛ АВ



СЭРЭЭТ АЧИГЧ МАШИНЫ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛУУЛАХ

ТАЛУУДЫН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА



“ЗҮРХ МАРТАХГҮЙ” ТӨСӨЛ

Зүрхний төрөлхийн гажигтай, эх орондоо хагалгаа хийлгүүлэх, гадаад орнуудад оношлуулахад туслалцаа үзүүлэх зорилготой Улаанбаатар Сонгдо Эмнэлгийн хамт олноос санаачлан хэрэгжүүлж буй нийгмийн сайн сайхны төлөөх “ЗҮРХ МАРТАХГҮЙ” төсөлд Шунхлай ХХК болон АПУ ХК-иуд нэгдэн, яаралтай хагалгаанд орох шаардлагатай хүүхдүүдийн хагалгааны төлбөр хандивлаж, бяцхан зүрхнүүдэд амьдрал бэлэглэлээ.



“SAVE ANGELS” ТӨСӨЛ

Эрүүл мэндийг дэмжих зорилгын хүрээнд АПУ ХК нь 2018 оноос хойш жил бүр JCI Монгол байгууллагын санаачилсан төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажилласаар ирсэн. Уг ажлын үр дүнд нярайн эндэгдлийг бууруулах түүнээс урьдчилан сэргийлэх болон оношлоход шаардлагатай тоног төхөөрөмжийн санхүүжилт хийсэн. 2020 онд олон залуу гэр бүлд элэг бүтэн амьдрах итгэл найдвар, аз жаргал бэлэглэх зорилготой “Save angels” төслийг дэмжин ажиллалаа.



ХАРИУЦЛАГАА НЭМЖ ХАМТДАА ДАВЬЯ АЯН

Улс орон даяар БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДАЛД шилжиж, цар тахалтай тэмцэж буй хүндрэлтэй цаг үед “Хариуцлагаа Нэмж Хамтдаа Давья” аяныг АПУ Хувьцаат компаниас санаачлан хэрэгжүүлсэн. Уг аяны хүрээнд өмнө нь цар тахлын голомт дээр бүх хүчээ дайчлан ажиллаж буй ОБЕГ, ХӨСҮТ, Дотоодыг Хамгаалах Их сургуулийн нийт эмч, сувилагч, ажилчин албан хаагч, сонсогч нарт сүү сүүн бүтээгдэхүүнээр дэмжлэг үзүүлсэн. Мөн АПУ компанийн нийт хамт олны зүгээс өөрсдийн санаачилгаар хандив цуглуулан, Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн эмч сувилагчдад хандивлалаа.



ТАЛУУДЫН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ХҮРТЭЭМЖТЭЙ ОНЫ ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА”-ААР ШАЛГАРЛАА

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Үндэсний зөвлөл, ХНХЯ-аас АПУ ХК-ийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага”-аар шалгарууллаа.

АПУ ХК нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн оролцоог сайжруулах чиглэлд 2020 онд идэвхтэй ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсдын тоог нэмэгдүүлж, хараагүй иргэдэд зориулж ажлын байрууд тусгайлан гаргаж, улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг ажлын байрандаа тус тус зохион байгуулж ажилласан билээ. Мөн ХУД-т оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгийн ихээр зорчдог авто замын уулзваруудын гэрлэн дохионд дуут дохиологч байрлуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, БЗД-ийн нутаг дэвсгэрт байрлах АПУ компанийн үйлдвэрийн дотоод болон нийтийн эзэмшлийн зам талбайг тусгай хэрэгцээт хүмүүст хүртээмжтэй болгон тохижуулан ажиллалаа.



ФС УЛААНБААТАР БАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЛАА

Монголын хөл бөмбөгийн дээд лигт чансаагаар тэргүүлэгчдийн нэг “ФС Улаанбаатар” хөл бөмбөгийн шигшээ багтай АПУ Хувьцаат компани хамтран ажиллаж, багийн тогтвортой үйл ажиллагааг тасралтгүй дэмжин ажиллаж, спортын хөгжилд хувь нэмрээ оруулж байна.



“ЦЭВЭР ГАР АЯН”

“Намуун Хүүхдийн сан” санаачлан хэрэгжүүлсэн ковид-19 цар тахлын улмаас ажлын байр нь түр хаагдсан, орлого нь тасарсан айл өрхүүдэд хүнсний тусламж, ариун цэврийн багц түгээх зорилготой “Цэвэр гар” аянд АПУ компани нэгдэж, Улаанбаатар хотын 8 дүүргийн зорилтод бүлгийн нийт 1000 өрхөд тусламжийн багц хүргүүлж, дэмжин ажиллалаа.



ISO СТАНДАРТ БА ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТАЙЛАГНАЛ



Чанар гэдэг нь зөвхөн бүтээгдэхүүний чанарын тухай ойлголт биш юм. Бүтээгдэхүүний чанараас гадна процессийн чанарыг хянаж баталгаажуулснаар бидний хийж буй бүхий л үйлдэлд чанар шингэсэн байдаг.

АПУ компани ISO9001 Чанарын удирдлагын тогтолцоо, ISO14001 Байгаль орчны удирдлагын тогтолцоо болон FSSC22000 Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны стандартуудыг хамтад нь нэвтрүүлсэн Монголын анхны компани юм.

Чанарын алба нь чанарын хяналт, чанарын баталгаажуулалт, чанарын удирдлагын тогтолцоо гэсэн үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Бүтээгдэхүүнийг зохион бүтээхээс эхлээд түүхий эд материалын чанарыг шалган, хүлээн авах, хадгалах, эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн, түгээлтэд гаргах хүртлэх бүхий л процессд сорилт, шинжилгээ, туршилт, чанарын хяналт, баталгаажуулалтын үйл ажиллагааг Олон улсын стандарт, журам заавартай нийцүүлэн, байнгын мониторингийн хяналт тавих цогц үйл ажиллагаа юм.

АПУ компанийн стратеги зорилгын нэг болох “Үлэмжийн дээд чанарыг бий болгох” зорилгын хүрээнд 2019 онд бид дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Процессын чанарыг сайжруулахын тулд “Quality Improvement Idea” аян
- Алба нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулан, мэдлэг чадвараа бусаддаа түүгээхийн тулд “Audit Eye” аян
- Баримт бичгийн хяналт, тархалтыг сайжруулахын тулд “Баримт бичгийн соёлыг бий болгох нь” хөтөлбөр

Бид үйл ажиллагаагаа Олон улсын стандарт, дүрэм, журманд нийцүүлэн, АПУ компанийн ажилтан бүрийн оролцоотойгоор чанарын соёлыг бий болгож, хэрэглэгчиддээ үлэмжийн дээд чанарыг бүтээгдэхүүн бүртээ амалж байна. Бидний амжилтын үндэс бол Чанар болон Монгол хүний олон жилийн туршлага, ур ухаан шингэсэн технологи юм.



ISO СТАНДАРТ БА ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТАЙЛАГНАЛ



АПУ групп компанийн хэмжээнд бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах болон судалгаа шинжилгээ хийдэг төв лаборатори 5, үйлдвэрлэлийн шугамын дэргэдэх бүтээгдэхүүний хяналтын дагуул лаборатори 9, нийт 14 лаборатори 24 цагийн үйл ажиллагаатай ажиллаж байна. Төв лабораториуд нь бүгд олон улсын стандартын байгууллагаас баталсан стандарт, дүрэм, журам, шинжилгээний арга аргачлал, норматив техникийн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажилладаг.

Эдгээр лабораториуд нь олон улсын сорилтын лабораториудын чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025 : 2018 стандартын шаардлагыг тогтмол ханган ажилласаар ирсэн ба Олон улсад лабораторийн тоног төхөөрөмжөөр тэргүүлэгч АНУ, Герман, Австри, Солонгос, ОХУ-ын орчин үеийн шилдэг, нано технологи бүхий өндөр мэдрэмжит тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон.

Манай лабораториуд нь үйлдвэрлэлдээ дотоод хяналтыг тавихаас гадна үйл ажиллагааныхаа чиглэлээр Heineken-ий олон улсын лабораториудын сорилт, шалгалтын байгууллага, Англи улсын Фапас-ын олон улсын лабораторийн ур чадварын уралдаан зэрэгт өндөр амжилттай оролцсон. Мөн Герман улсын VLB, Weihenstephan институт, ОХУ-ын Interlab, ФГБНУ ВНИИПБТ институт, Монгол улсын судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд, их дээд сургуулиудтай судалгаа шинжилгээний чиглэлээр хамтран ажилладаг судалгааны томоохон бааз юм.

АПУ Групп компанийн дотоод хяналтын лаборатори нь дараах бодлогыг баримтална.

- Лабораторийн чанарын удирдлагын тогтолцоо болон сорилт шинжилгээний нэгдмэл байдлыг ISO/IEC 17025 стандартын шаардлагад нийцүүлж, байнгын сайжруулалтаар хангана.
- Ажилтан ажиллагсдын хөгжил, техник технологид чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг ханган ажиллана.
- Болзошгүй санхүүгийн болон бусад хүчин зүйлээс хараат бус байдлаар үйл ажиллагаагаа тасралтгүй явуулна.



5 Санхүүгийн тайлагнал

- Дэлгэрэнгүй орлогын тайлан
- Санхүү байдлын тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- *Тайлагналын зарчим*
- *Тайлбар толь*

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2020	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2019
Борлуулалтын орлого	сая.төг	492,337.4	472,634.2
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	(263,409.6)	(260,200.1)
Нийт ашиг	сая.төг	228,927.8	212,434.2
Борлуулалт, удирдлагын зардал	сая.төг	(112,671.1)	(112,451.8)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	(540.9)	(410.3)
Бусад орлого	сая.төг	2,909.7	3,128.4
Бусад зардал	сая.төг	(2,785.0)	(3,305.5)
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	115,840.5	99,395.0
Санхүүгийн орлого	сая.төг	850.4	1,728.3
Санхүүгийн зардал	сая.төг	(2,248.1)	(2,575.5)
Татварын өмнөх ашиг	сая.төг	114,442.8	98,547.8
Орлогын албан татварын зардал	сая.төг	(25,699.9)	(22,434.9)
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	88,742.9	76,112.9
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Ашиг, алдагдал руу дахин ангилагдахгүй зүйлс:			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	сая.төг	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	сая.төг	(29.5)	35.3
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	88,713.4	76,148.2
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох	сая.төг	89,578.5	76,062.5
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	сая.төг	(835.6)	50.4
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	88,742.9	76,112.9
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох	сая.төг	89,549.0	76,097.8
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	сая.төг	(835.6)	50.4
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлогын нийт дүн	сая.төг	88,713.4	76,148.2
Нэгж хувьцаанд ногдох ашиг			
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	мян.төг	84.3	71.6

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2020	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2019
Хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	сая.төг	262,519.8	260,112.7
Биет бус хөрөнгө ба гүүдвил	сая.төг	87,305.9	92,149.0
Хойшлогдсон татварын хөрөнгө	сая.төг	1,252.3	605.0
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	351,078.1	352,866.8
Бараа материал	сая.төг	83,348.4	89,521.5
Урьдчилгаа, урьдчилж төлсөн зардал	сая.төг	17,664.4	9,352.7
Орлогын албан татварын авлага	сая.төг	-	3,908.6
Дансны болон бусад авлага	сая.төг	39,013.1	39,822.8
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалт	сая.төг	500.0	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	сая.төг	64,059.2	50,034.9
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	204,585.1	192,640.6
Нийт хөрөнгө	сая.төг	555,663.2	545,507.4
Эздийн өмч			
Хувьцаат капитал	сая.төг	106.3	106.3
Нэмж төлөгдсөн капитал	сая.төг	338,094.9	338,094.9
Нэгдлийн нөөц	сая.төг	(112,795.8)	(112,795.8)
Дахин үнэлгээний нөөц	сая.төг	100,177.6	101,458.1
Гадаад валютын хөрвүүлгийн нөөц	сая.төг	(21.3)	8.2
Хуримтлагдсан ашиг	сая.төг	129,937.4	154,411.1
Хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг	6,116.6	-
Нийт эздийн өмч	сая.төг	461,615.7	481,282.8
Өр төлбөр			
Хойшлогдсон татварын өглөг	сая.төг	18,088.6	19,383.8
Урт хугацаат түрээсийн өглөг	сая.төг	7,764.2	8,421.6
Ажилтны тэтгэмж	сая.төг	656.5	-
Урт хугацааны зээл	сая.төг	2,000.0	-
Урт хугацаат өр төлбөр	сая.төг	28,509.3	27,805.3
Богино хугацаат түрээсийн өглөг	сая.төг	2,318.6	1,700.6
Орлогын албан татварын өглөг	сая.төг	2,698.0	1,318.5
Дансны өглөг	сая.төг	11,312.4	12,001.8
Бусад өглөг	сая.төг	49,209.2	21,398.3
Богино хугацаат өр төлбөр	сая.төг	65,538.2	36,419.2
Нийт өр төлбөр	сая.төг	94,047.5	64,224.6
Нийт өр төлбөр ба эздийн өмч	сая.төг	555,663.2	545,507.4

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2020	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2019
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн ашиг	сая.төг	88,742.9	76,112.9
Тохируулга:			
Орлогын албан татварын зардал	сая.төг	25,699.9	22,434.9
Зээлийн хүүгийн зардал	сая.төг	20.5	-
Түрээсийн хүүгийн зардал	сая.төг	2,227.6	2,203.9
Хүүгийн орлого	сая.төг	(724.3)	(1,728.3)
Валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй гарз/(олз), цэвэр	сая.төг	(493.7)	(188.7)
Элэгдлийн зардал	сая.төг	32,266.9	32,134.4
Хорогдуулгын зардал	сая.төг	7,126.0	6,866.6
Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралт, цэвэр	сая.төг	502.9	170.3
Банкны үлдэгдэл дэх үнэ цэнийн бууралт	сая.төг	38.0	240.0
Бараа материалын үнэ цэнийн бууралт (буцаалт)	сая.төг	819.8	600.1
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	сая.төг	(26.0)	(197.3)
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	сая.төг	513.4	255.9
Хасагдсан үндсэн хөрөнгө	сая.төг	657.0	502.9
Биет бус хөрөнгө борлуулсны гарз	сая.төг	-	4.9
	сая.төг	157,370.8	139,412.4
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:			
Дансны авлага болон бусад авлага	сая.төг	96.6	(5,122.3)
Бараа материал	сая.төг	5,301.1	(14,408.3)
Урьдчилгаа	сая.төг	(8,315.9)	1,477.6
Дансны өглөг	сая.төг	(578.8)	21.1
Бусад өглөг	сая.төг	13,882.1	(580.3)
Ажилтны тэтгэмж	сая.төг	656.5	-
	сая.төг	168,412.4	120,800.2

		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2020	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2019
Зээлийн хүүний төлбөрт төлсөн	сая.төг	(101.2)	-
Түрээсийн хүүний төлбөрт төлсөн	сая.төг	(2,227.6)	(2,203.9)
Хүлээн авсан хүүгийн орлого	сая.төг	724.3	1,728.3
Төлсөн орлогын албан татвар	сая.төг	(22,375.0)	(31,688.7)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	144,433.0	88,635.9
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	сая.төг	(35,288.9)	(22,227.0)
Худалдаж авсан биет бус хөрөнгө	сая.төг	(1,352.8)	-
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг	-	(57.7)
Борлуулсан үндсэн хөрөнгө	сая.төг	1,027.3	1,004.5
Бусад санхүүгийн хөрөнгө оруулалтыг олж эзэмшихэд төлсөн	сая.төг	(500.0)	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(36,114.4)	(21,280.1)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Зээлийн эргэн төлөлт	сая.төг	-	-
Төлсөн ногдол ашиг	сая.төг	(101,739.6)	(77,121.3)
Түрээсийн өглөгт төлсөн	сая.төг	(2,137.7)	(1,241.8)
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	сая.төг	6,952.3	-
Урт хугацааны зээл авсан	сая.төг	2,000.0	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(94,925.1)	(78,363.1)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	сая.төг	(34.2)	23.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)	сая.төг	13,359.4	(10,983.4)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	50,034.9	61,123.9
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	(38.0)	(240.0)
Мөнгөн хөрөнгө дэх гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөлөл	сая.төг	702.9	134.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	64,059.2	50,034.9

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ		Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Нэгдлийн нөөц	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт эзэмшигчдийн өмч
2019 оны эхний үлдэгдэл	сая.төг	106.3	338,094.9	(112,795.8)	102,499.3	(6.6)	124,765.6	452,663.7	1,731.0	454,394.7
Нийт дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	-	-	76,062.5	76,062.5	50.4	76,112.9
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	-	-	-	-	35.3	-	35.3	-	35.3
Бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	-	-	(48,898.8)	(48,898.8)	-	(48,898.8)
Зарласан ногдол ашиг	сая.төг	-	-	-	-	-	1,420.1	1,420.1	(1,781.5)	(361.3)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн	сая.төг	-	-	-	(1,041.2)	(20.4)	1,061.6	-	-	-
2019 оны эцсийн үлдэгдэл	сая.төг	106.3	338,094.9	(112,795.8)	101,458.1	8.2	154,411.1	481,282.8	-	481,282.8
Нийт дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	-	-	-	-	-	89,578.5	89,578.5	(835.6)	88,742.9
Бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	-	(29.5)	-	(29.5)	-	(29.5)
Зарласан ногдол ашиг	сая.төг	-	-	-	-	-	(115,332.8)	(115,332.8)	-	(115,332.8)
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувьцаа	сая.төг	-	-	-	-	-	-	-	6,952.3	6,952.3
Хуритлагдсан ашиг руу шилжүүлсэн	сая.төг	-	-	-	(1,280.6)	-	1,280.6	-	-	-
2020 оны эцсийн үлдэгдэл	сая.төг	106.3	338,094.9	(112,795.8)	100,177.6	(21.3)	129,937.4	455,499.1	6,116.6	461,615.7

ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

ТАЙЛАГНАЛЫН НИЙЦЭЛ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд бэлтгэсэн. Уг тайланг Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт (“СТОУС”) 10 буюу “Нэгтгэсэн санхүүгийн Тайлан” хэмээх стандартын арга аргачлалыг ашиглан бэлтгэсэн.

ҮНЭЛГЭЭНИЙ СУУРЬ

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахдаа санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

БҮРТГЭЛИЙН БОЛОН ТОЛИЛУУЛГЫН ВАЛЮТ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн засгийн орчны үндсэн валют болно.

ТААМАГЛАЛ, ТООЦООЛОЛ БОЛОН ҮНЭЛЭМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС болон НББОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь няглан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцоолоос зөрүүтэй байж болно. Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг.

ГАДААД ВАЛЮТААР АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ. Компани нь зээл болон авлагыг анх үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

АВЛАГА. Уг хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг.

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР. Компани нь гаргасан өрийн бичиг, өр төлбөрийг тухайн ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн өр төлбөрийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙГ ЦЭВЭР ДҮНГЭЭР ТУСГАХ.

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анхны удаа өртгөөр нь хэмждэг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

ДАРАА ҮЕИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Хөрөнгийн бодит үнэ цэнийг Монгол Улсын хараат бус гуравдагч этгээд тогтоодог.

ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ.

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

ЭЛЭГДЭЛ.

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, орлогын тайланд бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь, дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг.

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Компани биет бус хөрөнгө худалдан авсан бөгөөд түүний ашиглалтын жилийг тодорхойлох боломжтой бол түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

Биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд үүнтэй холбоотой үүсэх олз ба гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

Компани бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг болгон капиталжуулдаг. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардлууд ордог. Үйлдвэрийн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн хувьд хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг өртөгт хуваарилдаг.

ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог.

ХОРОГДУУЛСАН ӨРТГӨӨР ИЛЭРХИЙЛСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Компани эдгээр хөрөнгүүдийг тусад нь мөн хамтад нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байгаа эсэхийг үздэг. Бүх мэдэгдэхүйц хэмжээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусад нь үнэлнэ.

САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ.

Тайлант үеийн эцэст бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгийн дансын үнэнд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

АЖИЛЧДЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ

АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААТ ТЭТГЭМЖ. Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

ТОГТООСОН ШИМТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ. Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

ХУВЬЦААТ КАПИТАЛ

ЭНГИЙН ХУВЬЦАА

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

ХАЛААСНЫ ХУВЬЦАА

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бууралт гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг. Халаасны хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

ХУВЬЦААТ КАПИТАЛ, НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ БА БУСАД НӨӨЦҮҮД

Эвэргрийн Инвестментс ХХК-тай нэгдсэн талаар Холбогдох эрх бүхий байгууллагуудаас зохих зөвшөөрлүүдийг шат дараатай авсны үндсэн дээр нэгдлийн ажил гүйлгээ 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөр дуусгавар болсон. Эцсийн үе шатанд Эвэргрийн Инвестментс ХХК компанид нэгдсэн бөгөөд компани нь

нэгдсэн компаниуд, тэдгээрийн охин компаниудын толгой компани болсон.

Нэгдлийн үр дүнд дараах өмчийн дахин зохион байгуулалтыг хийсэн:

2017 оны 8 дугаар сарын 18-ны өдөр компанийн хувьцаа эзэмшигчид нийт 338,127,000 мянган төгрөгөөр капиталыг нэмэгдүүлэх замаар Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд нийт 321,305 мянган ширхэг энгийн хувьцааг шинээр гаргасан. Уг капитал нь 32,130 мянган төгрөгийн хувьцаат капитал болон 338,094,870 мянган төгрөгийн нэмж төлөгдсөн капиталаас бүрдсэн.

Нэгдлийн нөөц

Бизнесийн нэгдлийн хүрээнд компанийн шилжүүлсэн төлбөр нь Эвэргрийн Инвестментс ХХК-тай хийсэн нэгдэлд зориулж шинээр гаргасан хувьцаа болно. Өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлоходоо бодит үнэ цэнийн 1 дүгээр шатлалын хэмжүүр болох компанийн хувьцааны зах зээлийн үнэ цэнийг ашигласан. Нэмж гаргасан хувьцааны бодит үнэ цэнэ болон хуулийн дагуу бүртгэгдсэн үнэ цэнийн зөрүү болох 112,795,804 мянган төгрөгийг нэгдлийн нөөц гэж бүртгэсэн.

ОРЛОГО

Бараа борлуулалтын орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэлд тусгадаг. Ингэхдээ компани эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд орлого ба өртөг зардлыг бодитоор хэмжих боломжтой байх ёстой.

БАРАА БОРЛУУЛАЛТ

Бараа агуулахаас ачигдан, худалдан авагчийн талбайд хүргэгдэж, худалдан авагч барааг хүлээн авч, эрсдэл болон өмчлөл нь худалдан авагчид бүрэн шилжсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг. Орлогын дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад борлуулалтын татварыг оруулдаггүй ба худалдааны хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр дүн байдаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭСИЙН ОРЛОГО. Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид төлөгдөх ижил хэмжээний хэсэгчилсэн төлөлтөөр орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн хөрөнгийн урамшууллыг түрээсийн нийт зардлын дүнд тооцон түрээсийн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн орлогыг олсон тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

БУСАД ОРЛОГО.

Компанийн үндсэн үйл ажиллагаанаас гадна бий болж буй орлогыг бусад орлого гэх бөгөөд тухайн орлогын эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай ба үүнийг найдвартай хэмжин тодорхойлох боломжтой болсон үед компани бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ОРЛОГО БА САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтаас хүртэх хүүгийн орлого орно. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд хуримтлуулан бүртгэдэг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд бүртгэдэг.

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

ХОЛБООТОЙ ТАЛУУД

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

ТАЙЛБАР ТОЛЬ

ТАЙЛАНТ ҮЕ

Аж ахуйн нэгж, байгууллагын ашиг, алдагдлыг тооцож буй хугацааг хэлнэ. Ерөнхийдөө улирал, жилийг хамруулж авч үзнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

ХӨРӨНГӨ

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болж, байгууллагын мэдэлд орсон бөгөөд ирээдүйд үр өгөөжөө өгөх нөөц, баялаг, хөрөнгө юм.

ББХ-БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгөтэй адил биетээр, бодитоор оршдоггүй хэдий ч эзэмшигчдэдээ давуу тал болон давуу эрхийг олгодог патент, лиценз, зохиогчийн эрх, барааны тэмдэг, нэр төр, гүүдвил гэх мэт удаан хугацаанд үнэ цэнэтэй байх актив (хөрөнгө)-ыг хэлнэ.

ҮХ-ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Байшин, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт худалдан борлуулах зориулалтгүй, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах буюу 1 жилээс бага хугацаанд борлогдож мөнгөн хөрөнгө болохгүй хөрөнгийг хэлнэ.

ЭБХ-ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийг хэлнэ.

ЭХ-ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ашиглагдах нэг жил буюу түүнээс бага хугацаанд бэлэн мөнгө болж хувирах хөрөнгийг хэлнэ.

УТЗ-УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

Ажил үйлчилгээ авахаас өмнө буюу үр дүн нь гарахаас өмнө төлсөн төлбөр

ДАНСНЫ АВЛАГА

Үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах мөнгөн дүн.

БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалт хамаарна.

МӨНГӨТЭЙ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөнд шууд хөрвөх нэгээс гурван сарын хугацаатай хөрөнгө оруулалт юм.

МӨНГӨН СУУРЬТ АРГА

Бэлнээр мөнгө хүлээж авсан үед нь орлогод, бэлнээр мөнгө төлсөн үед нь зардалд бүртгэх няглан бодох бүртгэлийн арга.

АККРУЭЛ СУУРЬТ АРГА

Мөнгө хүлээн авсан, эсхүл төлснөөс үл хамааран ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан орлогыг олсон, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

ХУВЬЦААТ КАПИТАЛ

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө юм.

ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн дүнг хэлнэ.

ӨР ТӨЛБӨР

Бусдад төлөх ёстой мөнгө (хувь хүн, компани, эсхүл Засгийн газрын өр байж болно).

УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийг хэлнэ.

БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг хэлнэ.

НДШ-НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх зорилгоор ажилчид болон ажил олгогчдод ногдуулах татвар.

ОТ-ОРЛОГЫН ТАЙЛАН

Компанийн олсон орлого, гаргасан зардлыг тодорхой хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон харуулсан тайлан

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон орлогыг хэлнэ.

БОРЛУУЛАЛТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Тайлант үед борлуулсан барааны өртгийг хэлнэ.

НИЙТ АШИГ

Байгууллагын тодорхой хугацаан дахь үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн илэрхийлэл буюу бизнес эрхэлж, эрсдэл хүлээсний төлөө авч буй үр өгөөж, компанийн нийт орлогоос бүх мөнгөн болон хийсвэр зардлыг хасч тооцно.

ҮАЗ-ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Бизнес эрхлэхэд гарч буй зардал.

ХТӨА

Хүү татварын өмнөх ашиг

ЦЭВЭР АШИГ

Компанийн орлогоос бүх төрлийн зардал болон татварыг хасаад үлдэж буй ашгийн хэмжээ.

ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Орлогын албан татварын зардал нь орлогын албан татварын өмнөх ашиг нь хувиар илэрхийлсэн

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Засгийн газраас аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогод ногдуулж буй татвар

МГТ-МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг харуулсан тайлан

ҮҮАМГ

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байгууллагын орлого олох үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн хөрөнгийг хэлнэ

ГХО

Гадаадын хөрөнгө оруулалт